



ҮЙЛ ЯВДАЛ

МӨРДЭСТЭЙ ЭМЧ, АЖИЛТНУУД БУУХИА ТЭМЦЭЭНД ӨРСӨЛДӨЖ БАЙНА



ЗХЖШ-ын даргын тушаалаар төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын эмч, эмнэлгийн ажилтнуудын дунд "Цэргийн эмнэлгийн тусгай бэлтгэл-2021" буухиа тэмцээнийг зохион байгуулж байна.

Тэмцээний нээлтийн ёслолын ажиллагааг энэ сарын 23-ны өдөр Хужирбулан дахь Зэвсэгт хүчний Сургалтын төвд зохион байгууллаа.

Энэхүү нээлтийн ёслолд ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг, Эрүүл мэндийн хэлтсийн дарга, хурандаа Т.Сүхбаатар, Цагдаагийн Ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Д.Манлайбаатар, Хил хамгаалах Ерөнхий газрын Цэргийн албаны зохион байгуулалтын газрын дарга, хурандаа Батбаатар болон бусад албан тушаалтнууд, баг, тамирчид оролцсон юм.

Цэргийн эмч, эмнэлгийн мэргэжилтний багаар ажиллах үр чадварыг нэмэгдүүлэх, эмнэлгийн шаталсан тусламжийг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэх, харилцан туршлага солилцох, цаашид олон улсын тэмцээнд оролцох бэлтгэлийг хангах зорилгоор уг тэмцээнийг зохион байгуулж байна.

Уг тэмцээнийг ЗХЖШ-ын Эрүүл мэндийн хэлтсээс санаачлан өнгөрсөн жилийн намар Зэвсэгт хүчний

нэгтгэл, ангиудын эмч, эмнэлгийн ажилтнуудын дунд зохион байгуулж, шилдгүүдээ шалгаруулж байсан бол энэ жилээс төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд явуулж байгаагаараа онцлогтой ажээ.

Тэмцээнд ЗХЖШ, ЦЕГ, ХХЕГ, ШШГЕГ, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн болон Тусгай хүчний цэргийн командлал, БИЦУГ, Цэргийн төв эмнэлгээс эрэгтэй, эмэгтэй тус бүр нэг баг, тамирчид өрсөлдөж байна.

Энэ талаар ЗХЖШ-ын Эрүүл мэндийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Ч.Оюунцэцэгээс тодруулахад "Цэргийн эмч, эмнэлгийн ажилтнуудын дунд халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулсны үндсэн дээр энэхүү буухиа тэмцээн нь хоёр өдөр үргэлжлэх ба тэмцээний эхний өдөр оролцогч багууд багийн нэгдсэн ажиллагаа, үр чадвараараа маш ширүүн өрсөлдлөө. Тэмцээний хоёр дахь өдөр хувь хүний буюу багийн ахлагч, сувилагч, эмнэлгийн зааварлагч, жолооч-дамнуургачны үр чадварыг сорьсноор нэгдсэн дүн гарна. Нэг баг нь 5 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд байгууллага бүрээс шилдэг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд оролцож, авьяас, үр чадвараараа сорьж буй болохоор тэмцээнийг улам сонирхолтой бас өрсөлдөөнтэй болгож байгаа" гэдгийг онцоллоо.

Хурандаа Б.ОТГОНБАЯР

"АЛДАР"-ЫН ТАМИРЧИН АЛТАН МЕДАЛИЙН ТӨЛӨӨ ӨРСӨЛДӨНӨ



ОХУ-ын Москва хотод зохион байгуулагдаж байгаа 58 дахь удаагийн Армийн дэлхийн аварга шалгаруулах боксын тэмцээнд "Алдар" спорт хорооны баг тамирчид 6 дахь жилдээ хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж байна.

Тодруулбал, 9 дүгээр сарын 23-ны өдөр "Алдар" спорт хорооны тамирчин, Т.Болортуул 57 кг-ын жинд

тулалдаж Беларусын боксчныг ялснаар дэлхийн аваргын финалд шалгарлаа.

Өнөөдөр дэслэгч Х.Энх-Амар 56 кг-ын жинд, ахлагч Х.Энхмандах 52 кг-ын жинд мөнгөн медалийн төлөө өрсөлдлөнө.

Ташрамд дурдахад Х.Энх-Амар, Х.Энхмандах хоёр төрсөн ах дүү бөгөөд Т.Болортуул нь нь Х.Энх-Амарын эхнэр юм.

"ЗҮРХНИЙ ЭХ ОРОН" ДУУ ТӨРЛӨӨ



БНӨСУ-д явагдаж байгаа НҮБ-ын мандаттай энхийг дэмжих ажиллагаанд нийт 52 анги, байгууллагаас шалгарсан дайчид үүрэг гүйцэтгэхээр ажиллагааны өмнөх бэлтгэлээ хангаж байна.

Ажиллагааны өмнөх бэлтгэлийн үеэр амралт, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, батальоны хэмжээнд зохион байгуулах соёл, урлаг, спортын арга хэмжээний агуулга, мөн чанарыг тайлбарлан таниулах зорилгоор урлагийн хэсэгчилсэн тоглолтын арга хэмжээг зохион байгууллаа.

Тус арга хэмжээний төлөвлөгөөг батальоны захирагчаар батлуулан хөтөлбөрийн дагуу явуулсан бөгөөд батальоны захирагч, хурандаа О.Заяат нээн үг хэлснээр тус арга хэмжээ эхлэв. Мөн хүчний энхийг дэмжих ажиллагааны хэлтсийн сургалтын төвийн багш нар урилгаар оролцсоноос гадна батальоны нийт бүрэлдэхүүнд зориулж мэндчилгээ дэвшүүлэв.

Урлагийн хэсэгчилсэн тоглолтын үеэр хангалт үйлчилгээний тасгийн

техникийн офицер, ахмад Б.Мөнх-Учрал мотобуудлагын батальоны сүлд дуу болох "Зүрхний эх орон" дууг бүтээж, дэд ахлагч М.Энхбат, Б.Энхжаргал нар "Зүрхний эх орон" дууг анх удаа дуулж сонирхуулсан нь батальоны нийт бүрэлдэхүүнд болон урилгаар ирсэн зочдод таалагдсаны дээр тасралтгүй алга ташилтаар талархсан сэтгэлээ илэрхийлэв.

Мөн батальоны цахилгаан хөгжмийн хамтлагийн хөгжимчид болох байлдааны хангалтын ротын захирагч, хошууч Г.Уранжаргал, хангалт үйлчилгээний тасгийн техникийн офицер, ахмад Б.Мөнх-Учрал нар "Эрчүүд" дуугаар ая дуугаа өргөсөн бол шуурхай штабын хэвлэл мэдээллийн төлөөлөгч, ахлах дэслэгч Ц.Бадамсүрэн "Миний эх орон" шүлгээр, сэтгэл зүйч офицер, ахлах дэслэгч Г.Баасанпүрэв "Хайр гижигдсэн цэргийн бүсгүй" дуугаар хөглөж, хуягт тээвэрлэгчийн ротын дэд ахлагч М.Энхбат "Хайр шингээсэн харц" дуугаа хүргэлээ.

Ахлах дэслэгч Ц.БАДАМСҮРЭН

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 281.769 +3361	ЭДГЭРСЭН 278.373 +5286	НАС БАРСАН 1086 +13
-----------------------------------	---------------------------	------------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 5132 +87	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 203	ЭДГЭРСЭН 4831
-----------------------------	----------------------------	------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 231,356,228
Эдгэрсэн Нийт: 208,027,975
Нас барсан Нийт: 4,741,625

Түүхэнд энэ өдөр

1987 он:

БХЯ-ны сайдын 505 дугаар тушаалаар Зэвсэгт хүчний 314 дүгээр анги байгуулагджээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
18	7

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
35	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,848.00	2,850.00
EUR	3,343.0	3,355.0
CNY	441.00	441.08
RUB	38.20	39.40
JPY	25.58	26.02
KRW	2.38	2.47

ЗУРХАЙ

2021.09.24 БААСАН ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 18/

НАМРЫН ДУНД УЛААГЧИН ТАХИА САРЫН ХОЁР ХАР ХӨХӨГЧИН ГАХАЙ ӨДӨР

Үс засуулбал:
Эд МАЛЫН ГАРЛАГАТАЙ Наран ургах, шингих: 06.42-18.47
Барилдлага: Түлэх Шүтэн барилдлага: Сэрэхүй Суудал: Отгоргүй

Аргын тооллын 9 сарын 24, Сугар гараг. Билгийн тооллын давхарласан 18, Гоё хүүхэн одтой, хөхөгчин гахай өдөр. Өдрийн наран 6 цаг 42 минутад мандан, 18 цаг 47 минутад жаргана. Тухайн өдөр хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр гэмт хэрэг илрүүлэх, гэм буруутныг шийтгэх, хараал, жатхыг буцаах, нялхсын хурим хийх, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн.

Газар ухах, худаг гаргах, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одоосод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.



цахим шууданд

ОРОЛЦООНЫ ЭНЭ УДААГИЙН ЭЭЛЖИД 264 ОРОЛЦОГЧ ХАМРАГДЛАА



Зэвсэгт хүчний 119 дүгээр анги

“Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл”-ийн хүрээнд V ээлжийн 264 оролцогч залуучуудыг вакуумжуулсан сургалтыг энэ сарын 19-ний өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 3-ны өдөр тус ангийн байрлалд байх Зэвсэгт хүчний ХЗЦК-ийн сургалтын төвийн байрлалд зохион байгуулж байна.

Энэхүү төслийн зорилго нь залуучуудад эрүүл, эртэч, идэвхтэй амьдралын хэв маяг, эх оронч үзлийг төлөвшүүлэх сургалт зохион байгуулж, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх замаар хөдөлмөрт бэлтгэж, ажилтай, орлоготой болгоход сурган дадлагажуулахад оршиж байгаа юм.

Төслийг залуучуудад ажил, амьдралынхаа гарааг зөв эхлүүлж, хөдөлмөрийн харилцаанд оролцоход шаардлагатай ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, залуучуудад уламжлалт болон орчин үеийн соёлын

ухааны яам, соёлын яамтай хамтран Зэвсэгт хүчний ХЗЦК-ын харьяа нэгтгэл, анги байгууллагын 70 гаруй офицер, ахлагч, ажилчин албан хаагч нар ажиллаж байгаа юм. Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын харьяа нэгтгэл, анги байгууллагаас томилогдсон салааны захирагч нар биеийн тамирын бэлтгэл, сэтгэл зүйн бэлтгэл, хотхоны дүрэм гэсэн сэдвүүдээр хичээлүүдийг оролцогч нарт зааж байгаа юм.

Залуучуудын вакуумжуулсан сургалтыг өдрийн 10 цагаар батлагдсан хичээлийн хуваарийн дагуу чанартай зохион байгуулж байгаа бөгөөд тус төсөлд Улаанбаатар хот, Баян-Өлгий, Говь-Алтай, Дорноговь, Увс, Хөвсгөл, Ховд, Дорнод, Өвөрхангай, Хэнтий, Баянхонгор, Булган, Дундговь, Сүхбаатар, Дархан-Уул аймгуудаас нийт 264 оролцогч хамрагдаж байна.

агуулгатай хослуулан хувь хүний хөгжил, эх оронч үзэл санаа, эрүүл, зөв амьдралын хэв маяг, төлөвшилийг суулгах, залуучуудад улс орны хөгжлийн үндэс болох гэр бүлийн утга учир, хамтын хүсэл мөрөөдөл, түүнд хүрэх арга замын талаар сургах зорилтын хүрээнд явуулж байна.

Төслийн үйл ажиллагаанд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Батлан хамгаалах яам, Боловсрол шинжлэх



БЭЛТГЭЛ ҮҮРЭГТНИЙ СУРГАЛТ БОЛЛОО



Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Монгол Улсын Дайчилгааны тухай хууль, Цэргийн албаны тухай хууль болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын 2021 оны цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнтэй явуулах сургалтыг Баянгол, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабуудаас цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнийг татан Зэвсэгт хүчний 120, 326 дугаар ангиудын материаллаг баазыг түшиглэн 5 төрлийн мэргэжлээр зохион байгууллаа.

Тус сургалтад хамрагдах иргэдийг халдвараас урьдчилан сэргийлж дүүргийн эрүүл мэндийн төв дээр түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авч, УОК-оос гаргасан зөвлөмжийн дагуу

халдвар хамгааллын дэглэмийг сахиулан богино хугацаанд чанартай явууллаа. Сургалтын явцад Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас Зэвсэгт хүчний 326 дугаар ангид хугацаат цэргийн алба хааж байгаа дайчдад халдвараас сэргийлэх зорилгоор 1000 ширхэг амны хаалт, 50 ширхэг гар ариутгагч, 2

ширхэг зайнаас халуун хэмжигч багаж, бусад амин дэмийн бүтээгдэхүүнийг ангийн захирагч, хурандаа Г.Отгонбаярт гардуулан өглөө.

Сургалтад хамрагдсан бүрэлдэхүүн батлагдсан хөтөлбөрийн дагуу бүрэн суралцаж үнэмлэхээ гардан авлаа. **Ахлах дэслэгч Б.БАТЦЭЦЭГ**



АРТИЛЛЕРИ, ЗЭВСГИЙН ТЭНХИМ-100 ЖИЛ



2021 онд Монгол Улсын Зэвсэгт хүчинд олон түүхт тэгш ой тохиож байгаа. Үүний нэг нь УБХИС-ийн “Артиллери, зэвсгийн тэнхим”-ийн 100 жилийн ой юм. Орчин цагийн Зэвсэгт хүчинтэйгээ нас чацуу тус тэнхимийн түүх тэртээ 100 жилийн өмнө жанжин Д.Сүхбаатар “Их даргын сургууль” байгуулж, анхны 3 төрөл мэргэжилтнийг бэлтгэж сургаснаар эхэлдэг. Тодруулбал, 1921 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 6 сарын хугацаатай 20 хүнийг их бууны мэргэжилтнээр сургасан нь тус тэнхимийн түүхийн эхлэл байжээ. Түүнээс

хойш өнөөдрийг хүртэл эх орныхоо төлөө халуун амь, бүлээн цусаа асгаруулсан үе үеийн эх оронч, их буучдыг тасралтгүйгээр сурган хүмүүжүүлж ирсэн. Түүхт ойн хүрээнд тус тэнхимийн эрдэмтэн багш нар нэлээдгүй ажлуудыг хийж гүйцэтгэж байгаагийн нэг нь өнөөдрийн “Артиллери, зэвсгийн тэнхим-100 жил” сэдэвт эрдэм шинжилгээний хурал юм. Тус хуралд эрдэмтэн багш нар, ахмад артиллерчид, залуу үеийн төлөөллийг оролцуулан “Артиллери, зэвсгийн тэнхимийн өнөө ба ирээдүй”, “Артиллерийн шинжлэх ухаан, түүний ухагдахуун,

боловсон хүчний хөгжил”, “Өнөөгийн артиллерийн боловсон хүчин бэлтгэж буй тогтолцоо зэрэг илтгэл тавьж хэлэлцүүлжээ.

“Артиллери, зэвсгийн тэнхим”-ийн 100 жилийн ойн хүрээнд артиллерийн цахим сургалтын технологи бүрдүүлэх зорилгоор хэд хэдэн төсөл хэрэгжүүлэх, хэрийн сургалтын төвд артиллерийн сургалтын хотхон байгуулах, тэнхимийн түүхэн замнал болон сургалтын хэд хэдэн ном бүтээх, сургалтын хөтөлбөрүүдийг шинэчлэх зэрэг нэлээдгүй ажлыг шат дараатайгаар хийж хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

ШИНЭ НОМ

ТӨРӨЛХ АКАДЕМИЙНХАА ОЙГООР...



алдарт бүтээл туурвилууд, Оросын нэгдүгээр Петр хаан өөрийн зургаар удирдан бариулсан “Петродворец” гэх үлгэрийн юм шиг цогцолборт нэгэн цагт Агаарын цэргийн инженерийн академи байрлаж байсан тухай, 1920 оны арваннэгдүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн эрдэм номын авшиг хүртээсэн тус академийн түүхэн замналаас дээжлэн бичжээ.

Сансрын анхны нисэгч Ю.Гагарин ном дуу сонсож суусан тус академийн үндсэн курсийг 1964 онд хошууч генерал Цогийн Геннадий дүүргэснээс хойш монголын 37 хүн дөрвөн мэргэжлээр суралцаж цэргийн нисэхийн инженерүүд болцгоосон аж. Монгол Улсын сансрын нисэгч, БНМАУ, ЗХУ-ын баатар, хошууч генерал Ж.Гүррагчаа, Техникийн ухааны доктор, профессор, бэлтгэл хурандаа Л.Лхагва, академийн Алтан медальтай дүүргэж хананд нь нэрээ анхлан мөнхөлсөн хурандаа Б.Эрдэнэбат, Агаарын цэргийн командлалын штабын дарга асан бригадын генерал Б.Батбаяр гээд академийнхаа нэрийн хуудас болж яваа нийт төгсөгчдийн дурсамж уг номын хойморт залагдсан нь сонирхол татна.

Цэргийн нисэхийн үүх түүхийг дагнан судалж цөөнгүй ном товхимол өлгийдөн авсан, өнөөдөр ч цаг зав, сэтгэл оюунаа бүрэн зориулж яваа инженер-бэлтгэл хурандаа Я.Даваасамбуу гуайд бүтээл туурвил нь төрж өссөн Хөвсгөл нутгийн сарьдаг уулс лугаа өндөр байхын ерөөл өргөө.

Профессор Н.Е.Жуковскийн нэрэмжит Агаарын цэргийн инженерийн академи үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан тус академийн 1979 оны төгсөгч, инженер-бэлтгэл хурандаа Ядамын Даваасамбуу санаачилан үзэглэж, мөн академийн “бүтээгдэхүүн”, доктор, профессор, хурандаа Батзоригтын Эрдэнэбат хянан тохиолдуулсан

“Бид Жуковскийнхан” ном уншигчдын гар дээр очоод удаагүй байна.

“Хүний булчингийн чадлыг биеийн жинтэй нь харьцуулбал шувуунаас 72 дахин дутуу юмсанж. Гэвч хүн төрөлхтөн оюуныхаа хүчээр сансарт дүүлж нисэх тийм цаг мөдхөн ирнэ” гэж 1898 онд нэрт профессорын хэлсэн үгээр үүдээ нээсэн уг номонд Оросын нисэх хүчний эцэг болсон Н.Е.Жуковскийн амьдрал,